

Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн менежмент хэрэгжүүлэх газрууд



Холбоо барих

Утас: +976-11-315595

Факс: +976-11-315595

И-мэйл: secretary@mongoliadisaster.org

Хаяг

НҮБХХ-ийн МОН/08/305 төсөл
“Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь”

Онцгой байдлын ерөнхий газар, 302-р өрөө, Партизаны гудамж-6, Улаанбаатар хот

Өмнөх үе шатуудад олсон амжилт

Төслийн 1, 2 дугаар үе шат 2002-2007 онд амжилттай хэрэгжсэн бөгөөд дараах үр дүнд хүрсэн байна:

- Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийг боловсруулж, батлуулахад дэмжлэг үзүүлсэн;
- Иргэний хамгаалалтын газар, Гал түймэртэй тэмцэх газар, Улсын нөөцийн газруудыг нэгтгэн Зэвсэгт хүчнээс ангид иргэний байгууллага болох Гамшгаас хамгаалах ерөнхий газрыг (өнөөгийн Онцгой байдлын ерөнхий газар) байгуулахад дэмжлэг үзүүлсэн;
- Шинэ тутам байгуулагдсан Онцгой байдлын ерөнхий газрын чадавхийг бэхжүүлэхэд тасралтгүй дэмжлэг үзүүлсээр ирсэн;
- “Монгол Улсын Гамшигтай тэмцэх чадавхийг 2006-2015 онд бэхжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэл”-ийг боловсруулахад Онцгой байдлын ерөнхий газарт дэмжлэг үзүүлсэн;
- Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийг бууруулах санаачлагыг нэвтрүүлэхийн тулд төсөлд хамрагдсан сумдад малчдын 40 хамтлагийг байгуулж, тэдгээрийн үүсгэл санаачлагыг бага хэмжээний санхүүгийн тусламжаар дэмжсэн;
- Төсөлд хамрагдсан аймаг, сумдуудад салбар хоорондын Гамшгийн эрсдэлийг бууруулах түншлэл, хамтын ажиллагааны зөвлөлүүдийг байгуулсан;
- Ядуурлыг бууруулах, байгаль орчныг хамгаалах, сайн засаглалыг бий болгох зорилтуудыг биелүүлэх чиглэлд мэдэгдэхүйц хувь нэмэр оруулсан.



Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь III шат



МОН/08/305 Төсөл



Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь



Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь

Өнөөгийн байдал

Дэлхийн хэмжээнд сүүлийн арван жилийн хугацаанд байгалийн болон хүний гаралтай гамшгийн давтамж хоёр дахин өсч, учирсан эдийн засгийн хохирол нь 1960-аад оныхоос 6 дахин их болжээ. Монгол Улсын хувьд ч гамшгийн давтамж, хор уршиг өссөөр байна.

Жишээ нь 1999-2000, 2000-2001 онд болсон зуданд нийт мал сүргийн 20 хувь хорогдож, 10 мянга гаруй малчин өрх амьжиргааны эх үүсвэрээ алдаж, улс орны эдийн засагт 413.8 тэрбум төгрөгийн (369 сая ам.доллар) хохирол учирсан нь 1991 оноос хойш Монгол Улсын авсан гадаадын зээл, тусламжийн 15 хувьтай тэнцэж байсан байна.

Гамшгаас хамгаалах үйл ажиллагаа нь гамшиг болсны дараа мэргэжлийн байгууллагуудын зүгээс эрэн хайх, аврах, хүмүүнлэгийн тусламж үзүүлэх арга хэмжээ авахад гол төлөв чиглэгддэг байсан бол эдүгээ гамшиг болохоос өмнө түүний эрсдэл, эмзэг байдлыг бууруулах, бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлд ажиллах бодит шаардлага тулгараад байна. Гэвч эдгээр үйл ажиллагааг дан ганц гамшигтай тэмцэх байгууллага хэрэгжүүлэх боломжгүй бөгөөд ард иргэд болон бүхий л салбар, байгууллагуудын оролцоо чухал юм.

Хэрэгжүүлэлт ба санхүүжилт

Хэрэгжүүлэгч байгууллага: Онцгой байдлын ерөнхий газар

Хэрэгжих хугацаа: 2008-2011

Санхүүжилт: Люксембургийн Засгийн газраас 1.3 сая ам.доллар, НҮБХХ-өөс 0.7 сая ам.доллар

Зорилт

Монгол Улсын гамшгийн эрсдэлийн менежментийн урт хугацааны стратегийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх замаар эмзэг байдлыг бууруулж, бэлэн байдлыг сайжруулж, гамшгийн менежментийг боловсронгуй болгох, онцгой нөхцөл байдлын үед хариу арга хэмжээ авах институцийн чадавхийг бэхжүүлж, улс орны, ялангуяа хөдөө орон нутгийн тогтвортой хөгжилд сөргөөр нөлөөлж буй цаг уурын өөрчлөлтөд дасан зохицоход нэмэр болох.

Энэхүү зорилтын хүрээнд дараах гурван үр дүн гарна:

Нэгдүгээр үр дүн:

Онцгой байдлын ерөнхий газар, түүний бүх салбаруудын онцгой нөхцөл байдлын үед хариу арга хэмжээ авах мэргэжлийн чадавхи сайжирна.

Хоёрдугаар үр дүн:

Түншлэл, хамтын ажиллагаа бэхжиж, гамшгийн эрсдэлийг бууруулах талаарх олон нийтийн мэдлэг, мэдээлэл дээшилнэ.

Гуравдугаар үр дүн

Гамшгийн эрсдэлийг бууруулахын тулд цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

Төсөл хэрэгжих нутаг

- Онцгой байдлын ерөнхий газрын 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэг дэх бүх хэлтсүүдийн чадавхийг бэхжүүлэхийн тулд дэмжиж ажиллана.
- Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн менежментийг доорх сум, дүүргүүдэд хэрэгжүүлж, гамшгийн эрсдэлийг бууруулах нутгийн иргэдийн бүлгүүдийг байгуулж, дэмжиж ажиллана:
 1. Ховд (Мөнххайрхан, Булган сум)
 2. Завхан (Нөмрөг, Цагаанчулуут сум)
 3. Хэнтий (Биндэр, Жаргалтахан сум)
 4. Дундговь (Баянжаргал, Говь-Угтаал сум)
 5. Булган (Тэшиг, Сайхан, Сэлэнгэ сум)
 6. Хөвсгөл (Эрдэнэбулган сум)
 7. Улаанбаатар (Сонгинохайрхан дүүргийн 4-р хороо, Чингэлтэй дүүргийн 17-р хороо)